

МЗЭ-ийн эвлэлийн шагналт, Болор цомын эзэн, нэрт яруу найрагч Хоодоогийн Эрдэнэбаатар агсаны “Уулсын дуулал” яруу найргийн цомгийн нээлтэнд зориулсан хvндэтгэлийн вйл ажиллагаа энэ сарын 10-ны vдэш Ховд аймгийн Хогжимт драмын театрт болов.

Энэхvв вйл ажиллагаанд нэрт найрагч агсаны ойр дотны хvмvвс утга зохиолын болон уран бvтээлийн ноход нь тvвний тухай дурсамж сэргээж, шvлэг зохиолоос нь уншиж, халуун яриа орнvвлж байснаас гадна шvлгэнд нь ая дан тааруулсан олон сайхан дуунуудыг мэргэжлийн дуучид уран бvтээлчид дуулан vзэгчдийн сонорыг мялаав.

Энэ veэр Ховд аймгийн Засаг дарга, мон аймгийн Аудитын газрын дарга асан Л.Галбадрах Хоодоогийн Эрдэнэбаатар агсаны нэрээр нэрлэгдсэн сан байгуулагдсаныг мэдэгдэж, сангийн гэрчилгээ, тамга тэмдэгийг торсон охин Э.Янжинлхамд нь гардуулж огсон юм. Сангийн тэргvвн Э.Янжинлхам болоод vвсгэн байгуулагчид хэлэхдээ “энэхvв сангийн вйл ажиллагаа нь нутаг орондоо утга зохиол, яруу найргийг хогжvвлэхэд хувь нэмэр оруулж хамтран ажиллах, освор залуу найрагчид, уран бvтээлчдийг дэмжихэд чиглэгдэнэ” гэсэн юм.

Цомгийн нээлт хvндэтгэлийн вйл ажиллагаанд Монголын зохиолчдын эвлэлийн Ховд аймаг дахь “Алтай” салбарын удирдлага, хамт олон монхvв Ховд аймгийн Иргэдийн толоологчдийн хурлын дарга, Засаг даргын Тамгын газрын толоолол, найрагч агсаны торсон нутаг Дуут сумын удирдлага хамт олон, Жаргалант сумын удирдлага, хамт олон, аймгийн бусад байгууллага, газруудын толоолол, найз ноход болон дэмжигч бусад хvмvвс хvндэтгэл vзvвлж, Х.Эрдэнэбаатар санд хандив оргосон юм.Â Â Â Â Â